

18. УТТА ФМ-9. ХН-4125
19. Мөн тэнд ХН— 4136
20. Мөн тэнд
21. Мөн тэнд
22. БНМАУ-ын түүх, УБ., 1984, 304—305-р тал
23. УТТА ФА. т-1 ХН-1
24. Мөн тэнд
25. Ц. Пунцагноров. «Монголын автономит үеийн түүх» УБ., 1955 36-р тал
26. УТТА ФА—5, хН—511
27. Л. Жамсран «Монголын 1911—1913 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үечлэл, шинж чанарын зарим асуудал» — Олон улсын Монголч эрдэмтдийн их хурал, III боть. УБ., 1979. 181—186-рт
28. Б. Ширэндэв. Монгол Ардын хувьсгалын түүх УБ., 1969 43—44-рт «Зарлигаар тогтоосон Халхын Түшээт хан аймгийн ван гүнгүүдийн Шастир. Дэд дээд 4-р»
30. Ц Пунцагноров. Дурдсан зохиол 86-рт

ЧИНГИС ХААН (1162—1227)

ШУА-ийн сурвалжлагч гишүүн, доктор

Н. ИШЖАМЦ

XIII зууны эхэн үеийн Ази, Европод Чингис хаан, татар-монгол хэмээх нэрс хүчтэй цууриатаж, дэлхий нийтийн түүхийн тавцан дээр монголын феодалын эзэнт гүрэн гарч ирсэн билээ. Энэ нь нүүдэлчин Монголын феодалын нэгдсэн улс байгуулагдаж, ойр, холын олон орныг байлдан дагуулсан бөгөөд түүнийг анх Чингис хаан оройлон удирдаж гүйцэтгэсэнтэй холбоотой юм. Монголын феодалын байлдан дагуулал, Чингис хааны тухай олон орны түүхийн сурвалж, янз бүрийн эрдэмтний судалгаа байвч уг асуудлыг үнэлэн дүгнэх дээр санаа бодол жигдрээгүй хэвээр байна.

Дундад зууны үеэс эхлээд Чингис хаан, Монголын байлдан дагууллыг зарим түүхчид маш дэвшилттэй сайн явдал хэмээж, зарим нь туйлын харгис бурангуй үйлийн тоонд оруулж үздэг байсны аль аль нь учир дутагдалтай болохыг бодит судалгаа нотолж байна. БНМАУ-ын түүхчид 1950—1960-аад оны үеэс эхлэн Чингис хааны үйл ажиллагааг үнэлэн дүгнэхдээ XI зууны эцэс, XIII зууны эхний Монгол угсааны тархай бутархай олон аймаг, овгийг нэгтгэж, Монголын феодалын нэгдсэн улс байгуулагдах явдалд түүний оруулсан хувь нэмрийг зохих ёсоор нааштай үнэлж, бусад улс орныг байлдан дагуулсныг нь Ази, Европын улс түмний түүх, түүнчлэн Монголынхоо амьдрал хөгжилд ч сөрөг үүрэг гүйцэтгэж гэж үзсээр ирэв.

* Б. Я. Владимирцов, Чингис-хан. Берлин-Пг. —М., 1922. БНМАУ-ын түүх, УБ, 1984, Сайшаал, Чингис хааны товчоон. I—II боть. Хөх хот, 1987.

М. С. Капица. Еще раз о роли Чингис-хана в истории, -- «Вопросы истории» сэтгүүл, 1988. №7

Л. Н. Гумилёв, Апокритический диалог, - «Нева» сэтгүүл, 1988. №3

Н. Сэр-Оджав, Түүхийн үнэний асуудалд, — «Үнэн» сонин 1988. 7. 28

Чингисийн үйл ажиллагаа, Монголын феодалын байлдан дагуулал нь тус орны дотоод, гадаад байдал, тухайн үеийн Ази, Европын олон улсын хоорондын байдалтай нягт уялдан гарч ирсэн юм. XII зууны дэд хагас, XIII зууны эхээр Монгол орон нь язгуурын Монгол тэргүүтэй Хамаг Монгол, Хэрэйд, Найман, Татар, Мэргэд, Ойрад, Онгуд, Хонхирад, Олхунууд, Хорь-түмэд зэрэг феодалын түрүү үеийн нүүдэлчдийн ханлиг хант улс, аймаг, овгууд болж хуваагдаад, дотор зуураа нийлэн нэгдэж чадахгүй, гүн гүнзгий зөрчил тэмцэлд автагдан байв. Тийм нөхцөлд 1162 оны 5-р сарын 31-нд Хамаг Монголын ханлигийн тэргүүн, ихээхэн хүч нөлөө бүхий сурвалжит язгууртан Есүгэй баатрын гэр бүлд ирээдүйн Чингис хаан-Тэмүжин хөвгүүн төрсөн байна.** Эцгийн нас барсаны дараа 9 настай үлдсэн балчир Тэмүжин Өэлүн эх, өөрийн төрсөн дүү нарын хамт ихээхэн хүнд амьдралыг туулж эрийн цээнд хүрсэн юм. 1189 онд Тэмүжин Онон, Хэрлэн, Туулын гурван голын эхний Хамаг Монголын ханлигийн нэгдмэл байдлыг сэргээж «Чингис хаан» цолтой түүний хан (бага хаан) болжээ. XII зууны эцэс, XIII зууны эхээр Чингис хаан татар, мэргэд, хэрэйд, найман, ойрад зэрэг Монгол угсааны бусад ханлиг, аймгуудыг Хамаг Монголын Ханлигийн захиргаанд нэгтгэж, 1206 онд Монголын феодалын нэгдсэн улсыг үндэслэн байгуулсан билээ. Монголын феодалын нэгдсэн улс байгуулагдсаны үр дүнд тус орны улс төр, засаг захиргааны нэгдмэл байдал бэхжин, феодалын ёс бүрэлдэн тогтож, бүхэл бүтэн Монгол угсаатан бий болж, монголчуудын нүүдэл иргэншлийн өвөрмөц соёл хөгжих нийгэм, улс төрийн нөхцөл бүрдсэн юм. Чингис хаан урьд нь хэрэйд, найман, онгудын зэрэг Монгол угсаатны аймгуудын дунд мэр сэр дэлгэрч байсан уйгуржин монгол үсгийг төрийн бичиг болгож, Их засаг хэмээх улсын цааз хуулийг зохиолгон гаргасан нь Монгол ба Төв Азийн бусад зарим нүүдэлчин улс аймгийн амьдрал, хөгжилд ул мөрөө үлдээсэн байна.

Тухайн үед хүчирхэг мандаж байсан Умард, Хятад дахь зүрчидийн Алтан улс Монголыг тусгаар улс хэмээн зөвшөөрч хүлээхгүй, ихээхэн түрэмгий бодлого явуулж байсан нь Монголын феодалын нэгдсэн улс байгуулагдсаны ачаар эцэс болж, тус орны гадаад байдал бэхжсэн юм.

Чингис хаан тийнхүү Монгол орныг нэгтгэж, нэгдсэн улс байгуулж, Монголын үндэсний төрийн тулгын чулууг тавилцан, тус орны тусгаар тогтнолыг бэхжүүлэх, нийгэм-эдийн засаг, үндэс угсаа, хэл соёлын хөгжилд тус дөхөм болох үйл ажиллагаа өрнүүлэн, түүнийг толгойлж хэрэгжүүлэлцсэн учир Монголын түүхэнд дэвшилт үүрэг гүйцэтгэсэн гэж үзэх нь зүйтэй мэт санагддаг юм. Тийм учраас түүнийг монголчууд дээр үеэс түүх, уран зохиол, аман уламжлалдаа үндэсний баатар болгон өргөмжилж, үндэсний эрх чөлөөний тэмцлийн сүлд туг мэт үзэж, шүтэн бишрэх явдал ч гарч байсан юм. Ар Монголд Чингисийн цагаан сүлд, хар тугийг тахиж байсан, Өвөр Монголын Ордост Чингисийн «Эзэн хороо» одоо болтол байсаар байгаа зэрэг нь чухам үүнтэй холбоотой ажээ. Орчин үед Чингисийг тахин шүтэж, бүх талаар хэт өргөмжлөн дэвэргэж эс болох боловч түүхийн үүднээс түүнийг зүй ёсоор зөв ойлгож бүрэн болох юм.

Нийгмийн анги, давхрааны хамаадлын хувьд Чингис хаан бол тухайн үеийн Монголын ноёлогч анги болох феодал ангийн хамгийн нөлөө бүхий

** Чингисийн төрсөн он цагийг янз бүрийн улс орны түүх сударт өөр өөрөөр бичсэн байдаг боловч «Лу, Алтан товч зэрэг бүх Монгол сурвалж, түүнчлэн Хятад, төвд ихэнх сударт чухамхүү 1162 он гэж заасан байдаг.

сурвалжит язгууртны төлөөлөгч байсан бөгөөд малчин ард, нийт хөдөлмөрчдийг дарлан мөлчигчдийн нэгэн байсан нь үнэн. Гэвч тэглээ гээд бид түүний үйл ажиллагааг үнэлэн дүгнэхдээ хэт магтах, дэндүү муучлах зэргээр өрөөсгөл хандаж болохгүй. Түүхэн зүтгэлтэн, өнгөрсөн үеийн явдлыг ямар ч анги, нам, бие хүний хувьд бид үнэн байдалд тулгуурлан бодитой, шудрага хандаж үнэлэх ёстой. Монгол ба бусад улс орны түүхэнд Чингис ямар үүрэг гүйцэтгэв гэдэг нь түүний үйл ажиллагаа урьдах үе, тухайн цагийн бусад түүхэн зүтгэлтнийхтэй харьцуулахад ямар байв, эцсийн эцэст ямар үр дүнд хүргэв, ямар үр дагавартай байв гэдгээс голлон шалтгаалах зүйл юм.

Чингисийн үйл ажиллагааг үнэлэх дүгнэхэд хамгийн тодорхой мэт боловч нэн ээдрээтэй зүйл нь даруй гадаад байлдан дагууллын асуудал билээ. Чингис Умард Хятад, Хар Киданы Баруун Ляо улс, Хорезм, Тангад зэрэг Азийн нэлээд улс орныг байлдан дагуулж Монголын феодалын эзэнт гүрнийг байгуулсан. Эрт, дундад ба шинэ үед ч гэсэн бусад улс орныг эзэлж, эзэнт гүрэн байгуулах явдал жирийн үзэгдэл, үндсэндээ зөвхөн ялах ялагдах, дийлэх дийлдэхийн асуудал байсан болохоор Монголын феодалын эзэнт гүрэн байгуулагдсаныг бусад эзэнт гүрнүүд бий болж байснаас илүү харгис юм уу эсхүл дутмаг дэвшилтэй байсан гэж үзэх үндэс үгүй. Чингис тэргүүтэй Монголын феодалын байлдан дагууллын бурангуй талыг илтгэсэн баримтыг сурвалжаас өрөөсгөл түүвэрлэн авч, түүний үндсэн дээр янз бүрийн дүн шинжилгээ хийсэн судалгаа одоо үед зонхилж байна. Гэтэл уг асуудлыг судлахад монголын байлдан дагуулал, түүний үр дүнд Ази, Европын олон орныг хамран бүрэлдсэн их эзэнт гүрний амьдрал, хөгжилд чухам ямар сайн, саармаг өөрчлөлт гарсныг бодит байдлаар сайтар нягтлан судалж байж хариуцлагатай дүн шинжилгээ хийх ёстой бизээ. Монголын байлдан дагуулал нь эзлэгдсэн орнууд төдийгүй, Японоос Баруун Европ, Өмнөд Азиас Сибирь хүртэлх эзлэгдээгүй бусад улс оронд ч багагүй нөлөө, хүртээлтэй байв. Монголын байлдан дагуулал эзлэгдсэн орнуудын хөгжлийг хэдэн зуун жилээр хойш татсан мэт үзвэл нэн инээдэмтэй хэрэг болно. Зарим эрдэмтэд Хятад, Иран, Орос, Энэтхэг зэрэг улс оронд феодалын тархай бутархай байдал ноёлж, нэгдмэл байдал нь удтал алдагдаад байсныг Монголын байлдан дагуулал эцэс болгосон гэж үзэж ирснийг ор тас үгүйсгэж үл больёу. Тэдгээр орны ард түмэн харийн байлдан дагууллын хүнд нөхцөлд ч гэсэн шургуу хөдөлмөр, баатарлаг тэмцэл, оюун билгээрээ тус тусын нэгдмэл байдлыг бэхжүүлж, эдийн засаг, соёлыг хөгжүүлэн, төрийн тусгаар тогтнолоо сэргээн, цаашид нэн эрчимтэй хөгжих боломжтой болж авсан байна.

Монгол гүрний дотор олон орны янз бүрийн арьс угсаа, иргэншил, соёл, хэл заншил бүхий ард түмнүүд их, бага аливаа байдлаар учирч уул залдан, бие биеийг танин мэдэж, зарим талаар ойртож ойлголцох болсон талтай. Монгол гүрний дотор ба түүгээр дамжин дорнод Ази, баруун Европ, өмнө, умрын эдийн засаг, соёл харилцан бие биед нэвтэрч түгэн байв. Монгол гүрний мөхсөний дараа дорнод Ази, Баруун Европын хоорондын хуурай замаар шууд харилцах боломж алдагдаж, гагцхүү гадаад далайгаар нэвтрэлцэх боломж үлдсэн байв. Сэргэн мандалтын үеийн Баруун Европод Япон, Хятад, Энэтхэг зэрэг Алс Дорнодын улс орнуудын тухай баримт мэдээг бараг гагцхүү монгол гүрний үеийн сурвалжийн материалд түшиглэн баримжаалж, өрнө зүг далайгаар аялж дэлхийг тойрон тэдгээр улс оронд хүрэх оролдлого анх хийгдэж эхэлсэн байдаг. Колумбо ч мөн тэгж яваад Энэтхэгт хүрлээ гэж бодон Америкийг нээж,

тэнд орших уугуул нутгийн улаан арьстан нарыг индиан нар (энэтхэгчүүд) гэж нэрлэсэн нь тэр гэдэг биз дээ. Энэ мэтээс үзсэн ч Чингис хаан, Монголын байлдан дагуулал, Монголын феодалын эзэнт гүрний сайн саармаг нөлөө, харгис, дэвшилт үр дагавар нь гагцхүү эзлэгдсэн улс орон, зөвхөн тухайн цаг үеэр хязгаарлагдаагүй, нэн давуу орон, цагийг эзэмдсэн их үйл явдал байсан ажээ.

Ертөнцийн улс түмний түүх, Ази, Европын орнуудын амьдрал, хөгжилд бүхэл бүтэн үеийг эзэлж, ул мөрөө үлдээсэн тийм үйлийг хэрэв тэр нь дан харгис шинжтэй байсан бол монгол шиг цөөн тооны хэдэн нүүдэлчид, Чингис мэтийн ганц эр хэдий сүрхий байлаа ч гэсэн бүтээж хүч хүрэхгүй байсан бизээ. Тийм дуулиантай үйл нэгэнт бүтсэн болохоор түүнийг заавал харгис бурангуй байгаад бүтэв гэж үзэхэд бэрх. Чингис хаан, Монголын байлдан дагуулал, Монголын феодалын эзэнт гүрэн бий болж, нэлээд удал оршин тогтносон нь огт санамсаргүй хэрэг биш ч байж магад. Монголын феодалын эзэнт гүрэн шиг их гүрэн байгуулагдах нь зайлшгүй шаардлагатай зүйл биш байлаа ч гэсэн түүний бий болох бодит боломж нөхцөл бүрдээд байсны улмаас Чингис хаан, түүний үр ач нарын байлдан дагуулал амжилт олсон хэрэг. Түүнийг хэрэгжүүлэхэд Чингисийн төрийн бодлого, цэрэг дайны стратеги, тактик, хүннү сяньби нарын үеэс эхлэн Монгол нутаг, Төв Азид оршин амьдарч байсан нүүдэлчин улс түмнүүдийн цэрэг-улс төрийн уламжлал шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байж болно. Хэрэв тийм уламжлал байгаагүйсэн бол Монгол гүрэн шиг их эзэнт гүрэн, Монголын байлдан дагуулал шиг нүсэр аян дайн, Чингис шиг байлдан дагуулагч гарч ирэх байсан, эсэх нь хараахан тодорхойгүй.

Чингис хаан зөвхөн Монголын төдийгүй, нийт Төв Азийн нүүдэлчин улс түмний цэрэг-улс төр, дэлхийн нийтийн түүхийн нэрд гарсан томоохон зүтгэлтэн мөн. Гэвч түүний хийсэн аян дайн, Монголын феодалын байл дан дагууллыг үнэхээр зарим талын дэвшилттэй байлаа ч гэсэн бусдыг түрэмгийлж, цус урсган, эвдэж сүйдэлснийх нь хувьд бид сайшааж бахархдаггүй юм.

**ХЯТАДТАЙ ХАРИЛЦААГАА
САЙЖРУУЛАХ ТАЛААР МАХН,
АРДЫН ЗАСГИЙН ГАЗРААС
ГАРГАСАН ХҮЧИН ЧАРМАЙЛТ
(1921—1925 он)**

Түүхийн ухааны дэд эрдэмтэн
Р. ОТГОН

МАХН үүсч байгуулагдах үеэсээ эхлэн хятадын их ард түмэнтэй эв найрамдалтай аж төрөх гэсэн монголын ард түмний чин эрмэлзлэлийг илэрхийлж байв. Тухайлбал Монгол Ардын Нам 1921 оны гуравдугаар сарын 25-нд гаргасан уриалах бичигтээ «Дэлхийн империализмд боолчлогдон дарлагдсан бүх дэлхийн ба Ази тивийн эрх чөлөөгүй, колонийн ард түмэн, хөдөлмөрчин ард түмний эрх ашиг, эв санал нэг байдаг хий-